

Ирэх 10 жилд эрүүл мэндийн бодлого, технологийн хүрээнд бүх нийтийн анхаарлын төвд байх асуудлууд

Шинэ аравны эхлэл нь эрүүл мэндийн салбарын өнөөгийн эрэлт хэрэгцээ болон тулгамдаж буй асуудлуудын талаар ярилцах сайхан боломжийг олгодог. 2019 оны сүүлээс дэгдэж эхлэн 2020 он гарсаар улам хүндэрч буй нөхцөл байдалтай холбоотой шинээр үүссэн, урьдчилан таамаглаагүй өвчин эмгэгт улс орны болон олон улсын бэлэн байдлыг харгалзан үзэх нь нэн чухал юм. Эрүүл мэндийн бодлого, технологийг ирээдүйн арван жилийн хугацаанд үр дүнтэй, тогтвортой хөгжүүлэхэд эдгээр зүйлсд анхаарлаа хандуулах нь зүй ёсны асуудал билээ.

Эрүүл мэндийн чиглэлээр тулгамдаж буй асуудал багасахгүй байна. Ялангуяа дэлхий даяар өсөн нэмэгдэж буй халдварт бус өвчин, аялал жуулчлалтай холбоотой тахлын хэмжээнд хүрэх эрсдэлтэй амьсгалын замын вирусын гаралтай халдварт өвчний асуудал ч анхаарлын төвд байна. Уханийн шинэ коронавирус 2019-nCoV-ын тархалт үүнийг нотолж байна¹.

Эрүүл мэндтэй холбоотой дараагийн нэг чухал асуудалд хүн амын хөгшрөлттэй холбоотой асрамжийн газрын хомсдол, буурай хөгжилтэй орнуудаас хөгжингүй орнууд руу чиглэсэн иргэдийн шилжилт хөдөлгөөн, цаг уурын өөрчлөлт болон байгаль орчны бохирдлын нөлөөлөл орж байна. Агаарын бохирдол нь зүрх судасны үйл ажиллагааны эмгэг үүсэхэд нөлөөлж байгаа нь бохирдлыг бууруулахад үр дүнтэй шийд хэрэгтэйг анхааруулсаар байна^{2,3}.

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд нь дэлхийн бүх улс орны иргэдийн эрүүл мэнд, энх тунх байдал, хөгжил цэцэглэлтийг урт удаан хугацаанд хангах, шударга, тогтвортой байдлыг бий болгоход чиглэсэн билээ. Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхэд эдийн засаг, байгаль орчин, нийгмийн хөгжлийн талаар үндэсний болон олон улсын хэмжээнд зохицуулсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хоол, шим тэжээлийн дутагдал, таргалалт нь эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж буй тэргүүлэх шалтгаан юм⁴. Чихрийн шижин нь дэлхийг бүрхсэн тахлын хэмжээнд хүрсэн бөгөөд зүрх судас, бөөрний архаг эмгэг ба бусад ноцтой хүндрэлүүдийн тохиолдын тоог нэмэгдүүлж байна. Мөн уур амьсгалын өөрчлөлт нь хур тунадас ихээр орох, хэт халах, ган гачиг үүсэх зэрэг цаг агаарын өөрчлөлтөөр дамжуулан хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хандлагатай байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ирэх арван жилийн хугацаанд хэрхэн анхаарах вэ? Өндөр хөгжилтэй орнуудад ч эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх ажилтнуудын хомсдол байна. Түүнчлэн хүн амын насжилт, зүрх судасны эмгэг болон Альцгеймерийн өвчтэй хүмүүсийг асрах хүний нөөцийн хомсдолтой бид нүүр тулаад байна. Хөгжлийн буурай шатанд байгаа орны эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг өндөр хөгжилтэй орнуудад ажиллуулах шийдэлд хүрэх боловч энэ нь тогтворгүй, цаашлаад буурай орнуудын хувьд шударга бус явдал юм.

Их Британи нь Европын холбооноос 2020 оны 1-р сарын сүүлээр албан ёсоор гарч байгаа нь тус улсад үүсээд байсан эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний хомсдлыг улам гүнзгийрүүлэх болно^{5,6}. Мөн эмийн хангалтын талаар ч асуудал үүсэх магадлал өндөр байна.

АНУ-ын зүгээс баримталж буй тусгаарлах бодлого, худалдааны татварын өөрчлөлтийн улмаас эм, эмнэлгийн хэрэгслийн өртөг нэмэгдсэж НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтын эрүүл мэндийн үзүүлэлтийг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх хандлагатай байна. НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд эрүүл мэндийн бодлогыг амжилтанд хүргэх гол зорилт бол эрүүл мэндийн хүртээмжтэй тусламж, үйлчилгээг санхүүгийн бэрхшээлгүйгээр бүх хүнд үзүүлэх явдал гэж тодорхойлсон билээ.

Нянгийн тэсвэржилт нь дэлхийн улс орнуудад аюул занал хэвээр байх болно. ДЭМБ болон бусад орнууд нянгийн тэсвэржилттэй тэмцэх чиглэлээр амбицтай санаачлага, төлөвлөгөө боловсруулсан билээ. Гэсэн хэдий ч, нянгийн тэсвэржилтэд хамгийн их өртсөн бүс нутгууд, түүний дотор Сахарын Африкийн орнуудын нянгийн тэсвэржилтийн тархалтын талаарх мэдээлэл хангалтгүй байгаа нь асуудлыг улам хүндрүүлж байна^{7,8}. Нянгийн тэсвэржилтийг бууруулахад олон талт хамтын ажиллагаанаас гадна эмчилгээний шинэ эмийн зохистой хэрэглээний удирдамжийг улс орнуудад үр дүнтэй хэрэгжүүлэх зэрэг алхмууд шаардлагатай болно.

Анагаах ухааны дүрс оношилгооны аргууд улам нарийсч хөгжих ба төрөхөөс өмнөх болон төрсний дараах эрт үеийн гений оношилгоо, эмчилгээг клиникийн практикт нэвтрүүлэх боломжтой болно. Эмчилгээний шинэ аргууд, нөхөн төлжүүлэх эм, ген засварлах эмчилгээ, илүү нарийн бичил мэс засал ба робот эмчилгээ, эмчилгээний радиологи мөн чихрийн шижин, зүрхний өвчнийг эмчлэх, өвдөлт намдаах зориулалтын шинэ төхөөрөмжүүд бий болно.

Түүнчлэн цахим эрүүл мэндийн тусламжтайгаар өвчтний эрүүл мэндэд хяналт тавих үүргийг эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд биш өвчтөнд өөрт нь шилжүүлэх зэрэг ажлыг ирээдүйд хийх болно. Дижитал эрүүл мэндийн сул тал нь буруу ташаа мэдээлэл түгээх эрсдэл юм. Иймд үүнийг удаан хугацаагаар эмчилгээ хийлгэх шаардлагатай цусны даралт ихсэх эмгэгийн үед хэрэглэхэд тохиромжгүй билээ.

Нийгмийн эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй өөр нэг зүйл бол вакцины хэрэглээтэй холбоотой ард иргэдийн дунд тархсан эргэлзээ юм. Жишээлбэл, улаанбурханы эсрэг вакцинжуулалт хүн амын дунд, зарим бүс нутагт эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийн дунд буурч байгаа нь сэтгэл түгшээж байна^{9,10}. Үүнтэй тэмцэх зорилгоор Европын өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах төвөөс Европын Эмийн Агентлагтай хамтран вакцины талаарх мэдээллээр үнэн, бодит мэдээллээр ард иргэдийг хангах, дархлаажуулалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Дижитал технологийн хөгжил нь эрүүл мэндийн технологийн тоо томшгүй олон шинэчлэлийг авчирч байгаа боловч эргээд бидний эрүүл мэнд, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байх магадлалтай юм. Жишээлбэл, хиймэл оюун ухаан, ухаалаг гар утас, 5G гэх мэт. Эдгээр шинэлэг зүйлээс ямар үр дагавар гарах вэ, тэдгээрийн ашиг тусыг нэмэгдүүлж, аюулыг хэрхэн багасгах вэ? гэсэн асуудлууд биднийг чилээсээр байна.

[Donald R.J.Singer^a](#)

[KenRedekop^b](#)

<https://doi.org/10.1016/j.hlpt.2020.02.003>Get rights and content

Ашигласан хэвлэл

[1]

C. Huang, Y. Wang, X. Li, *et al.* **Clinical features of patients infected with 2019 novel coronavirus in Wuhan**

China Lancet (2020 Jan 24), [10.1016/S0140-6736\(20\)30183-5](https://doi.org/10.1016/S0140-6736(20)30183-5)

S0140-6736(20)30183-5

[Google Scholar](#)

[2]

H. Xu, T. Wang, S. Liu, R.D. Brook, *et al.* **Extreme levels of air pollution associated with changes in biomarkers of atherosclerotic plaque vulnerability and thrombogenicity in healthy adults**

Circ Res, 124 (5) (Mar 2019)

e30-e43

[Google Scholar](#)

[3]

S. Morton, D. Pencheon, G Bickler **The sustainable development goals provide an important framework for addressing dangerous climate change and achieving wider public health benefits**

Public Health, 174 (Sep 2019), pp. 65-68

[Article](#)

[Download PDF](#)[View Record in Scopus](#)[Google Scholar](#)

[4]

B.A. Swinburn, V.I. Kraak, S. Allender, *et al.* **The global syndemic of obesity, undernutrition, and climate change: the Lancet Commission report**

393 (10173) (23 Feb 2019), pp. 791-846, [10.1016/S0140-6736\(18\)32822-8](https://doi.org/10.1016/S0140-6736(18)32822-8)

[Article](#)

[Download PDF](#)[View Record in Scopus](#)[Google Scholar](#)

[5]

The Lancet Oncology **UK national health service-beyond repair?**

Lancet Oncol, 19 (3) (Mar 2018), p. 267

[Article](#)

[Download PDF](#)[View Record in Scopus](#)[Google Scholar](#)

[6]

D.R.J. Singer, R Giuliani **Uncertainty continues about access to medicines after Brexit**

Health Policy Technol, 7 (4) (2018), pp. 323-324

[Article](#)

[Download PDF](#)[View Record in Scopus](#)[Google Scholar](#)

[7]

M. Carroll, A. Rangaiahagari, E. Musabeyezu, D. Singer, O Ogbuagu **Five-year antimicrobial susceptibility trends among bacterial isolates from a tertiary health-care facility in kigali, rwanda**

Am J Trop Med Hyg, 95 (6) (Dec 2016), pp. 1277-1283

[CrossRef](#)[View Record in Scopus](#)[Google Scholar](#)

[8]

UN interagency coordination group on antimicrobial resistance **No time to wait: securing the future from drug-resistant infections. Report to the Secretary-General of the United Nations**

World Health Organization, Geneva (April 2019)

[Google Scholar](#)

[9]

C.C. McClure, J.R. Cataldi, S.T O'Leary **Vaccine hesitancy: where we are and where we are going**

Clin Ther, 39 (8) (Aug 2017), pp. 1550-1562

[Article](#)

[10]

[Download PDFView Record in ScopusGoogle Scholar](#)

Vaccine hesitancy. European Centre for Disease Prevention and Control.

<https://www.ecdc.europa.eu/en/immunisation-vaccines/vaccine-hesitancy> Accessed 29th January 2020.

[Google Scholar](#)